



М. Чингэс

МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

Уг оны 28-р сарын 10 өдөр

Дугаар 165

Улаанбаатар

Зарим хүмүүсийг суралцуулах тухай

Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцах хүмүүс сонгон шалгаруулах 1999 оны уралдаант шалгалтын дүн, Өндөр хөгжилтэй орны магистрантурт суралцагчдыг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах ажлыг хариуцсан комиссын 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Байгаль орчны сайдын 1999 оны 8 дугаар сарын 11-ний 101 дугаар тушаалыг үндэслэн **Жамсансүрэнгийн Ариунжаргалыг** Нидерланд улсын байгаль орчны инженерийн олон улсын институтын магистрантурт ус судлал, мэдээлэл зүйн мэргэжлээр, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын 1999 оны 5 дугаар сарын 11-ний А / 71 дүгээр тушаалыг үндэслэн **Тангадын Чингисийг** АНУ-ын Остин дахь Техасын их сургуулийн магистрантурт газрын тосны хайгуулын мэргэжлээр, мөн сайдын 1999 оны 6 дугаар сарын 11-ний А / 89 дугаар тушаалыг үндэслэн **Чойнзонгийн Наранцацралыг** АНУ-ын Небраскийн их сургуулийн магистрантурт арьс шир, ангийн үсний технологийн мэргэжлээр, Дэд бүтцийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 1999 оны 5 дугаар сарын 11-ний 46 дугаар тушаалыг үндэслэн **Дугаржавын Түвшинг** АНУ-ын Денвер хотын Колорадагийн их сургуулийн магистрантурт механик инженерийн мэргэжлээр, **Хорлоогийн Оюундолгорыг** мөн сургуулийн магистрантурт компьютерийн, **Дашнямын Сэнгэлмааг** мөн сургуулийн магистрантурт соёл, урлагийн удирдлагын мэргэжлээр Гэгээрлийн яамны нэр дээр тус тус суралцуулсугай.

2. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам" -ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулан холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сан / Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар / С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.



САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

А.БАТТӨР